

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХДУГААР ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо | 6/26/2019 2:00 PM

Хурал хийсэн газар | Улаанбаатар хот, Чингэлтэй

дүүрэг, 5-р хороо, Холидэй Инн зочид буудал, 2 давхар хурлын танхим

Эхэлсэн цаг | 14:30

Дууссан цаг | 16:40

Хурлыг зарласан: Монос Хүнс ХХК

Хурлаар хэлэлцэх асуудал:

- ✓ “Монос Хүнс” ХХК-ийг ХК болгон хэлбэрийг өөрчлөх
- ✓ “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн санг өөрчлөх, шинэчилсэн дүрмийг батлах
- ✓ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ✓ ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох

Хурлын ирц: 78%

Тэмдэглэл хөтлөгч: З.Осоржам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: П.Тодрол – Үйл ажиллагаа хариуцсан захирал
Тооллогын комиссын дарга: Э.Амарболд – Санхүүгийн менежер
Тооллогын комиссын гишүүд:
Н.Цагаанхүү – Хуульч
Г.Буяндэлгэр–Тооцооны нягтлан бодогч

ХЭЛЭЛЦСЭН СЭДЭВ

Хэлэлцэх асуудал:

- ✓ “Монос Хүнс” ХХК-ийг ХК болгон хэлбэрийг өөрчлөх
- ✓ “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн санг өөрчлөх, шинэчилсэн дүрмийг батлах
- ✓ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ✓ ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлын дарга, Монос Хүнс ХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал П.Тодрол хурлыг нээж, тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн № МХ06/201905 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолыг уншиж танилцуулав. Тогтоолоор танилцуулсан асуудлууд:

1. Хурлаар хэлэлцэх асуудал
2. Хурлын зарыг олон нийтэд мэдээллэсэн өдөр болон суваг
3. Санал хуудсаар санал авсан хугацаа
4. Хурлын дарга болон тооллогын комиссын бүрэлдэхүүний танилцуулга

Хурал эхлэхэд буюу 14 цаг 35 минутанд Тооллогын комиссын дарга, Монос Хүнс ХК-ийн Санхүүгийн менежер Э.Амарболд хурлын ирцийг 71%-тай, хурал хуралдуулах нөхцөлийг хангаж байна хэмээн танилцуулж, хурлыг эхлүүлэв.

Хурлыг нээж Монос Хүнс ХХК-ийн ТУЗ-ийн дарга, хувьцаа эзэмшигч Л.Хүрэлбаатар үг хэлж, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчиддээ талархсанаа илэрхийллээ.

Хувьцаа эзэмшигч Эрдэнэбат: ХК болсоны дараа ч Л.Хүрэлбаатар гуайн өмнөх 286 195 300ш хувьцаа нь хэвээрээ байна. Тэгэхээр 30 хувь буюу 122 655 128ш хувьцааг нэмж гаргасан гэсэн үг үү?

Хурлын дарга П.Тодрол: Тийм. Нэмж гаргасан байгаа.

Асуулт хариулт №3.

Хувьцаа эзэмшигч Нямдаваа: Хувьцаа эзэмшигч бүр хувьцааныхаа тооноос хамаарч өөр өөр саналын эрхтэй байгаа ба тус санал хураалтын програм үүнийг тооцоолсон уу?

Хуульч Н.Цагаанхүү: Тиймээ, кумулятив аргаар санал хурааж байгаа ба энэ програм нь тус аргын дагуу бүтээгдсэн юм.

Асуулт хариулт №4.

Хувьцаа эзэмшигч Тунгалаг: Хараат бус гишүүн дээр өөрийнхөө нэрийг дэвшүүлсэн. Энд танилцуулж буй хараат бус гишүүдийг ямар шалгуураар сонгон шалгаруулж, танилцуулж байгаа вэ? Бид энд хурлаар сонгохгүй байсан уу?

Хурлын дарга П.Тодрол: Хуулийн дагуу хараат бус гишүүнд тавигдах шаардлагууд бий юм. Бидэнд нийт 11 анкет ирсэнээс шалгуур хангасан 3 хүнийг сонгож та бүхэнд танилцуулж байна.

Санал зөвлөмж №1.

Хувьцаа эзэмшигч Солонго: Хурлын явцаас харахад хурлын дарга болон хуульч гэх мэт залуучууд өөрсдийгөө хөгжүүлэх хэрэгтэй гэж зөвлөмөөр байна. Хуралдаа сайтар бэлдэх хэрэгтэй, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх байдлыг илүү сайжруулаарай. Залуучууд Л.Хүрэлбаатар гуайн нэр хүндийг бодож, маш их анхаарч ажиллах хэрэгтэй. Харин санал хураалтын арга их дэвшилтэт байна. Хувьцаа эзэмшигчдэд хэлэхэд хуулиа унших хэрэгтэй, ТУЗ-ийн сонгон шалгаруулалт болон хурлын санал хураалт бол хуулийн дагуу явж байна гэж үзэж байна.

Хурлын дарга П.Тодрол: Зөвлөгөөг хүлээн авлаа. Танд баярлалаа

Санал зөвлөмж №2.

Хувьцаа эзэмшигч Дашдорж: Хурлын үйл ажиллагаа, зохион байгуулалт сайн явагдаж байна. Дараагийн арга хэмжээ орохыг санал болгож байна.

Хурлын дарга П.Тодрол: Та бүхэнд баярлалаа. Цайны завсарлагад урьж байна.

Санал хураалт 15 цаг 30 минутад өндөрлөж, саналын дүнг нэгтгэж эхлэв.

Санал хураалтын дүнг нэгтгэх хооронд хувьцаа эзэмшигчдийн асуултанд бүрэн тодруулга өгөх үүднээс Хуулийн зөвлөх Д.Ганзориг МУ-ын Компанийн тухай хуулин дахь ТУЗ-ийн хараат бус гишүүний шалгуурыг танилцуулав.

Ингээд ТУЗ-ийн сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээ баяр хүргэе.”

ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон хүмүүстээ баяр хүргэж, үг хэлэхийг урьлаа.

ТУЗ-ийн гишүүн Ч.Чинзориг: “Сайн байцгаана уу, намайг Ч.Чинзориг гэдэг. Хамгийн сүүлд 2004-2008 онд Кобегийн их сургуульд компанийн засаглалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. 2008 онд Компанийн засаглалын институтыг Монголд байгуулж, ерөнхийдөө сүүлийн жилүүдэд энэ чиглэлээрээ ажилласан. Компанийг илүү нээлттэй болгох чиглэлээр судалгааны ажлуудыг хийсэн ба Монос Хүнс ХК-д 63,000ш хувьцаа эзэмшиж байгаа. Тийм учраас жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж ажиллахаа амлаж байна.”

ТУЗ-ийн гишүүн Б.Долгормаа: “Сайн байцгаана уу, миний нэр Б.Долгормаа. СЭЗИС-ийг санхүүч, нягтлан бодогч мэргэжлээр төгссөн, банк санхүү, бизнесийн салбарт нийт 16 жил ажилласан. Санхүүч хүнийхээ хувьд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр судалгааны ажлыг хийдэг ба тус зах зээлийн хөгжил шинээр бий болж буй хувьцаат компаниудаас ихээхэн хамаарч байна. Иймээс компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд анхаарч ажиллахаа илэрхийлж байна.”

ТУЗ-ийн гишүүн Ч.Баттогтох: “Сайн байцгаана уу, намайг Б.Баттогтох гэдэг. Би АШУҮИС-ийн микробиологийн тэнхимийн эрхлэгчээр ажилладаг ба АУ-ын доктор, дэд профессор цолтой. Миний мэргэжил эмч, мөн микробиологич учраас хүнсний аюулгүй байдал, хүнснээс хамаарсан халдвар, аюулгүй байдал тал руугаа ихээхэн анхаарч ажиллана.”

Хурлын дарга П.Тодрол санал асуулгын дүнд үндэслэн “Компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх, дүрмийг шинэчлэн батлах тухай”, “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” тогтоолуудыг баталж, 16 цаг 11 минутанд уншиж танилцууллаа.

Хурлын төгсгөлд Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, хувьцаа эзэмшигч Л.Хүрэлбаатар болон Х.Ананд нар үг хэлэв.

Л.Хүрэлбаатар: “Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Тус компанийн өмнөх ТУЗ нь 10 гаруй жил ажилласан туршлагатай ба Англи улсын иргэн Чарльз Глоор хараат бус гишүүнээр ажиллаж байсан. Тухайн үед Чарльз Глоор Монголд бус гадаадад ч хараат бус гишүүнтэй ТУЗ ховор байдаг, танай дээр хараат бус гишүүн ажилладаг мөн хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үүргийн хуваарилалт зөв байна гэж хэлж байсан. Иймээс, бидэнд туршлага бий. Мөн, шинэ гишүүдээр гадаадад төгссөн, санхүүгийн магистр, доктор, анагаахын доктор зэрэг шилдэг, сайн залуучууд сонгогдсон байна. Бидэнд итгэл хүлээлгэж сонгосон та бүхэнд өөрийн болон бусад гишүүдийнхээ өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлэе. Энэ бол эрх мэдэл биш хариуцлага юм. Компания хамгийн үр ашигтай, үр дүнтэй ажиллуулахын төлөө хичээж ажиллах болно.”

Х.Ананд: “Хувьцаа эзэмшигчдийн хувьд сонсохыг хүлээж буй зүйлсийн нэг нь компанийн үйл ажиллагаа болон хувьцааны ханш байдаг. Монос Группийн хувьд компаниудаа KPI менежментээр удирдаж, компаниудынхаа мэдээг сар бүр авдаг. Монос Хүнс компанийн хувьд 5 сарын өссөн дүнгээр борлуулалтын 95%-ийн, цэвэр ашгийн 129%-ийн гүйцэтгэлтэй байна. Хувьцааны үнийн хувьд сүүлийн 3 долоон хоногт 72 болтлоо өссөн ба өнөөдрийн байдлаар 71 төгрөгийн ханштай байна. Хагас жилийн ТУЗ-ийн хурлын мэдээ тайлан, гүйцэтгэл, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаатай холбоотойгоор

хувьцааны ханш цаашдаа өснө гэсэн хүлээлттэй байна. Мөн, ТУЗ-ийн гишүүнээр сонгосон та бүхэндээ баярлалаа.”

Хурлын дарга П.Тодрол 16 цаг 40 минутанд хурлыг хаав.

Тэмдэглэл хөтөлсөн: *З.Осоржам* З.Осоржам

Тэмдэглэл хянасан:

ХУРЛЫН ДАРГА



..... П.ТОДРОЛ

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА, ГИШҮҮД

..... *Э.Амарболд* Э.АМАРБОЛД

..... *Н.Цагаанхүү* Н.ЦАГААНХҮҮ

..... *Г.Буяндэлгэр* Г.БУЯНДЭЛГЭР